

МЕТАФОР ХЭРЭГЛЭЭГ ГАДААД ХЭЛНИЙ СУРГАЛТАНД ҮНДЭСНИЙ СЭТГЭЛГЭЭНИЙ ХЭВ ШИНЖЭЭР ИЛЭРХИЙЛЭХ ТУРШИЛТ СУДАЛГАА

С.Ганцэцэг ^{1,a*} (Доктор, (Ph.D) Дэд Профессор)

Т.Сумъяа ^{2,b} (Докторант, Дэд Профессор)

Э.Оюун-Эрдэнэ ^{3,c} (Докторант, Ахлах багш)

^{1,2,3} Англи хэлний багш, Гадаад хэлний Тэнхим, Мандах Их Сургууль, Монгол улс
^agantsetseg@mandakh.mn, ^bsumiya@mandakh.mn, ^coyunerdene@mandakh.mn

Хураангуй

Метафорыг илэрхийлэгч үгс дангаараа объектив утгатай үгсийн сангийн нэгж юм. Харин нийлэмжийн түвшинд утгын сэтгэлгээний субъектив чанарыг салбар шинжлэх ухаануудын уулзварт судлах асуудлыг эрдэмтэд сонирхсоор байна. Метафорын энэхүү концептлаг шинж нь гадаад хэлийг сурч байгаа хүний сэтгэлгээний хэв шинжийг тэрхүү хэлээр илрэх соёлын менталитэд¹ уусгаж таниулах хэрэгцээ зайлиггүй урган гарч байна. Тиймээс бид судалгааны ажилдаа Мэргэжлийн англи хэлэнд илэрч буй метафор шинжийг үндэсний сэтгэлгээний хэв шинжийн үүднээс судалж, англи хэлний заах арга зүйг боловсронгуй болгох санал дэвшүүлж байна. Англи хэл судалж буй оюутнууд зорилтот болон үндэсний хэл, соёлын шүтэлцээт байдлыг төрөл бус хэлэнд зэрэгцүүлэн судалж, соёлын мэдлэг, чадамжтай мэргэжилтэн төлөвшихөд судалгааны ажлын ач холбогдол оршино.

Түлхүүр үгс: мэргэжлийн англи хэл, заах арга зүй, метафор, сэтгэлгээний субъектив чанар, үндэсний сэтгэлгээний хэв шинж

¹ Менталит-үндэсний сэтгэлгээний төлөвшил

ОРШИЛ

Өнөөгийн хүн төвтэй нийгэмд конструктивизм, когнитивизм², прагматизм, экзистенциализмын онолуудыг их, дээд сургуулийн сурганы арга зүйд баримталж, хөгжүүлэх сургалт, оюуны хөгжлийн суурь чиг хандлага болж байна. Эдгээр үзэл баримтлалууд нь суралцагчдын сонирхол, сэдлийг хөгжүүлэх, тэдний бодит хэрэгцээнд тулгуурласан шинжлэх ухаан хоорондын уялдаат зарчим бүхий сургалтын орчныг бүрдүүлж, сургалтын хөтөлбөрийн уян хатан боловсруулалт, арга технологийн оновчтой хэрэглээг хангахад ач холбогдолтой юм.

Сүүлийн жилүүдэд дэлхийн улс үндэстнүүдийн соёлын ялгаа, орон зай, цаг хугацаа, эдийн засаг, нийгмийн амьдралын хэв маяг, үндэсний сэтгэлгээний онцлогийг метафороор илэрхийлэх хандлагыг төрөл бус хэлний зэрэгцүүлсэн судалгаанд авч үзэх шаардлага тулгарч байна.

Судалгааны арга

Бид Мандах ИС-ийн оюутнуудад мэргэжлийн англи хэл-2 хичээлээр англи хэлний метафор хэрэглээг үндэсний сэтгэлгээний хэв шинжийн үүднээс зэрэгцүүлэн заах арга зүйн талаар тандалт болон туршилт судалгаа хийсэн үр дүнг доор танилцуулж байна.

1. ҮНДСЭН ХЭСЭГ

Метафорийн тухай ойлголтыг хамгийн анх Грекийн философич Аристотель “Туурвилзүй” бүтээлдээ чухалчлан авч үзсэн бөгөөд метафор нь эртнээс өрнө дорнын утга уянгын зохиол бүтээлд түгээмэл хэрэглэгдсээр иржээ. Түүнчлэн 1980-аад оноос хэл шинжээч Ж.Лакоф, М.Жонсон нар метафорын тухай онол үзэл баримтлалыг хэл шинжлэлийн судалгаанд дэвшүүлсэн. Тэд ерөнхий хэл шинжлэлийн үүднээс метафорын мөн чанар нь нэг юмны гол шинжийг өөр зүйлд оноож, ойлгож, хүлээж авахад оршдог бөгөөд энэ нь зөвхөн хэлэнд буюу өөрөөр хэлбэл үгэнд хамаарах төдий зүйл биш юм гэж тодорхойлж байжээ. (2002)

20-р зууны сүүлээс метафор судлалыг сэтгэц, танин мэдэхүй, бүтэц хэл шинжлэл гэх мэт салбар шинжлэх ухаануудын өргөн хүрээнд судлах болжээ. Сэтгэц хэл шинжлэлийн үүднээс хүний сэтгэхүйн үйл явц нэлэнхүйдээ метафорчлагдсан байдаг (Lakoff) гэж үзсэнээр бүтээлч сэтгэлгээ бол мэдээлэл авахаас эхлээд шийдэлд хүрэх хүртэл үргэлжлэх сэтгэхүйн нийлмэл үйл юм гэж тодорхойлдог (Ц.Оюунчимэг, 2012). Өөрөөр хэлбэл үйл явдлыг ахуй, юмс, үзэгдэл гэх мэт бодит ойлголтод тулгуурлан зүйрлэх, ёгтлох, тойруулах зэрэг хийсвэр аргаар бодьжуулж, илэрхийлэх явдал нь сэтгэхүйн үйлдлүүдтэй холбоотой байдаг гэж үздэг.

Метафорыг когнитив хэл шинжлэлийн концептуаль метафорын хүрээнд судлах болсон ба энэхүү онолыг анх Ж. Лакофф, М. Жонсон нар 1980 онд “Metaphore dans la vie quotidienne” номондоо тусгаж, метафорын тогтолцоо нь когнитив механизм мөн гээд хүний сэтгэхүйн явц их олон тохиолдолд метафорлог гэж үзсэн. Үүнээс үзэхэд ухахуун концепт³ нь ухагдахуунаас үндэсний онцлогийг агуулснаараа ялгагддаг байна. Өөрөөр хэлбэл ухагдахуун нь уг юмны гол шинжийг заадаг бол ухахуун нь гол бус шинж (сэтгэл хөдлөл, дүрслэл, үнэлэмж)-ийг агуулсан байдаг гэж Ю.С.Степанов, В.А.Маслова (2007) нарын эрдэмтэд үздэг. Харин эрдэмтэн Ц.Магсар (2016) когнитив онолын үүднээс метафорыг тодорхойлохдоо бодит

² Когнитивизм-танин мэдэхүйн онол

³ Концепт-ухахуун (үндэсний онцлогийг агуулсан шинж)

байдлыг танин мэдэх хэрэгсэл, хүний туршлагыг эрэмбэлж, ертөнцийн талаарх мэдлэг төсөөллийг бүтэцчилэх багаж хэмээн онцгойлон үзсэн. Энэ нь метафорыг бүтээгч үгс дангаараа бие даасан обьектив утгатай, үгсийн сангийн нэгж хэдий ч нийлэмжийн түвшиндээ сэтгэлгээний субъектив чанарыг агуулж байдгийн хувьд суралцагчийн танин мэдэх үйл ажиллагааг бүтээлч шийдлээр зохион байгуулах, сэдэлжүүлэх, тэдний бие даасан бүтээлч үйлийг хөгжүүлэхэд чиглэсэн орчин үеийн чиг хандлагатай нийцэж байгаа юм.

Бүтэц хэл шинжлэлийн үүднээс Америкийн угсаатан зүй судлаач Бенжамин Ли Уорф, хэл шинжээч Эдвард Сапир нарын Сапир-Уорфын хэлний харьцангуй таамаглалаар хэлний бүтэц нь тухайн хэлээр яригч ард түмний сэтгэлгээ болон бодит ертөнцийг танин мэдэх арга хэлбэрийг тодорхойлно гэж үздэг байна (Carroll, 1958). Өөрөөр хэлбэл, өөр өөр хэлээр яригч бүлэг хүмүүс, ард түмэн ертөнцийг өөрөөр хүлээн авч, өөрөөр сэтгэдэг гэж үздэг. Тухайлбал, бүх ард түмэнд нийтлэг байдаг цаг, орон зайн категори нь өөр өөрөөр илэрч байдаг.

Энэхүү дэлхийн олон үндэстний сэтгэлгээний нийтлэг болон ялгаатай хэв шинжээс үүдэн гадаад хэлийг заах арга зүйн асуудалд нэг талаас соёлыг илэрхийлэх хэл, нөгөө талаас хэлээр илрэх соёл зэрэг ухагдахууны харилцан шүтэлцээний асуудалд олон судлаачид анхаарлаа хандуулж байна. Судлаач Чантал, Крозет нарын “Соёл хоорондын харилцааны чадамж-Хэлний боловсрол” бүтээлд гадаад хэлийг эзэмшиж байгаа хүмүүс зорилтот хэлээр (англи хэл) илэрч буй аспектүүдийг ойлгож, тэдгээрийг олон соёлын харилцаанд ашиглахад зорилтот хэл ба соёлын шүтэлцээт байдлыг ойлгосноор соёлын мэдлэг бүтээж, соёлын үнэлэмж төлөвшиж, улмаар соёл хоорондын харилцааны чадамж эзэмшдэг хэмээн судлаачид томъёолжээ (1995). Эрдэмтэн Ж.Баянсан (2002) соёл-хэлт үндэстний эртнээс нааш аж төрж ирсэн нутаг орон, түүний байгалийн байдал, эрхэлж буй аж ахуй, аж төрөх ёс буюу амьдралын хэв маяг, ёс заншил, шашин шүтлэг тэргүүтний өвөрмөц онцлогоос үүдэж тухайн юмс үзэгдэл, үйл явдал, шинж чанар, нөхцөл байдал зэргийг үнэлэх үнэлэмжийн жишиг хэмжүүр эталонийг⁴ бий болгосон байдаг гэж үзжээ. Жишиг хэмжүүр нь харьцууллаас үүсч, харьцуулалт нь хэл шинжлэл, уран зохиол судлалын үндэс цөм нь зүйрлэл үүсэх гол арга учир тойруулал, егөөдөл, ёгтлол, хэтрүүлэл нь эдгээрээс сурвалжтай нь тухайн үндэстний сэтгэлгээний хэв шинжийг тодорхойлох гэрч баримт болдог гэж эрдэмтэд үздэг байна. Энэ талаас нь авч үзвэл дэлхийн улс үндэстэн далд утгатай шууд бус нэрлэлт үүсгэх тухайлбал зүйрлэх, тойруулах, егөөдөх, зэрэг олон аргаар метафорыг хэрэглэдэг бөгөөд үүнийг хэрхэн ойлгох нь харилцагчийн суурь мэдлэгтэй холбоотой байдаг.

Бид МБИС-ийн оюутнуудад мэргэжлийн англи хэл-2 хичээлээр англи хэлний метафор хэрэглээг үндэстний сэтгэлгээний хэв шинжийн үүднээс зэрэгцүүлэн заах арга зүйн талаар тандалт болон туршилт судалгаа хийсэн үр дүнг доор толилуулж байна.

2. ТАНДАЛТ СУДАЛГАА


Мандах их сургуулийн мэргэжлийн англи хэл-2 хичээлийг судалж байгаа оюутнуудаас тандалтын болон туршилт судалгаа авч, анализ хийж дүгнэлээ. Тандалт судалгааны үр дүнг график 1,2-оор харуулав.

1-р даалгаварт “**eat-away at profit**” метафор (зүйрлэл)-ыг хэлц үйл үг, өвөрмөц хэлц, үйл үгийн алинд нь хамааралтайг сонгох асуулт оруулсан нь оюутнуудын англи хэлний үгзүйн болон хэлзүйн мэдлэгийг тандах зорилготой байлаа.

Энэ даалгаварт “Хэлц үйл үг” гэсэн хариултыг нийт судалгаанд оролцогчдын 40%, “Үйл үг” гэсэн сонголтыг 14% тус тус сонгосон нь суралцагчид үйл үг, хэлц үйл үгийг өвөрмөц хэлцээс нарийвчлан ялгаж мэдэхгүй байгаа нь харагдаж байна.


⁴ Эталон-үндэстний соёлын үнэлэмжийн жишиг хэмжүүр

2-р даалгавраар мэргэжлийн англи хэлний агуулгын хүрээнд судлагдаж буй англи метафорыг (зүйрлэлийг) монгол хэлэнд зүйрлэх утгатай нь тохируулах асуулга нь төрөл бус хэлийг зэрэгцүүлэн судлаж байгаагийн хувьд эх хэл болон үндэсний сэтгэлгээний онцлог



өгсөнөөр оюутан өвөрмөц хэлцийг үйл үг, хэлц үйл үгээс ялган таних чадвар (65%) өссөн байна.

Хэл шинжлэлийн үүднээс өвөрмөц хэлцийн талаар ерөнхий ойлголт өгөөгүй тохиолдолд түүнийг үгсийн сангийн утгын хувьд хольж будилах нь энгийн үзэгдэл юм.



хэрхэн илэрч байгааг тандахыг зорьсон.

Даалгаврын гүйцэтгэлийн дүнгээс нийт 5 оноо буюу бүх хэллэгийг зөв тохируулж чадсан суралцагч 32%, 4 оноо авсан суралцагч 0%-тай, 3 оноо авсан суралцагч 27%, 2 оноо авсан суралцагч 8%, 1 оноо авсан суралцагч 14%, 0 оноо авсан нь 19%-ийг тус тус эзэлж байна. Энэ үр дүн оюутнуудын сэтгэхүйн үйл харьцангуй метафорчлагдсан (32%) байгааг илэрхийлж байна. Нөгөө талаас метафорын талаарх ойлголтогүй хэдий ч үндэсний сэтгэлгээний онцлог шууд бусаар илрэх хандлагатай 14%, огт ойлголтогүй 19%) байгаа нь оюутнууд эх хэлний суурь мэдлэг хангалтгүй байгаатай холбоотой. Иймд багш нар гадаад хэлний заах арга зүйд үндэсний соёлын менталитийг хөгжүүлэх аргыг ашиглах шаардлага гарч байгаа юм.

Туршилт судалгаа

Туршилт судалгааг оюутны танин мэдэхүйн чадварт тулгуурлан өвөрмөц хэлц нь үгийн утга шилжиж өөр нэгэн ухахуун, утга санааг илэрхийлэх ба тухайн ард түмний сэтгэлгээ нэвт шингэсэн, нийлэмж үг юм гэсэн ойлголтыг туршилт судалгааг оюутны танин мэдэхүйн чадварт тулгуурлан өвөрмөц хэлц нь үгийн утга шилжиж өөр нэгэн ухахуун, утга санааг илэрхийлэх ба тухайн ард түмний сэтгэлгээ нэвт шингэсэн, нийлэмж үг юм гэсэн ойлголтыг туршилт судалгааны 2-р даалгаварт гадаад хэл заах (сонсох ба хэл ярианы, харааны төсөөллийн, биеийн хөдөлгөөн, оролцоонд суурилсан) аргуудыг ашиглан оюутнуудад зүйрлэлүүдийг тохируулах хэлбэрээр (Pigs get fat, hogs get slaughtered -Шунал ихэдвэл шулам болно, Fat cat-нударган баян) өгч метафорыг (зүйрлэл) хэрхэн ойлгож байгааг авч үзэв. Үүнээс үзэхэд туршилт хичээлд оролцсон нийт оюутнуудын 3% хангалтгүй үнэлгээ авсан нь тэдний үндэсний соёлын суурь үнэлэмж /мэдлэг/ дутмаг мөн тухайн ухахууныг хэрхэн хүлээн авч байгаа хийсвэрлэн сэтгэхүйн хурд харилцан адилгүй байгааг илэрхийлж байна.


Нөгөөтэйгүүр оюутнуудын 97% нь метафор утгыг эх хэл, үндэсний сэтгэлгээний онцлогт тулгуурлан таньж мэдэснээр төрөл бус хэлний ижил ба ялгаатай талыг таньж ойлгох, улмаар хэрэглээнд оруулах чадвар төлөвших хандлагатай байгааг илтгэж байна.

Оюутны танин мэдэхүйн чадварт тулгуурлан зорилтот буюу англи хэлний өвөрмөц хэлцийг тогтоох, бодит харилцаанд хэрэглэхэд тухайн хүний ерөнхий суурь мэдлэг болоод зорилтот болон төрөлх хэл, соёлын шүтэлцээт байдалтай салшгүй холбоотой байна.



Зураг 5-аар туршилт хичээлд оролцсон оюутнуудын 92% нь метафорыг ойлгож хэрэглэхэд а) сонсох ба хэл ярианы арга (audio-lingual method), б) харааны төсөөллийн арга, в) биеийн хөдөлгөөн, оролцоонд суурилсан (kinesthetic) аргуудыг илүү үр дүнтэй гэж үзсэн бол 8% нь сэтгэхүйн хурд удаан, сурахуйн үйлд хандах хандлага сул, ерөнхий суурь мэдлэг хангалтгүй байна.

Туршилт судалгаанд сургалтын сонсох ба хэл ярианы арга (audio-lingual method), харааны төсөөллийн арга (visual method), биеийн хөдөлгөөн, оролцоонд суурилсан (kinesthetic) аргуудыг хослуулан ашигласан нь үр дүнтэйн дээр харааны төсөөллийн (visual method) арга нь метафорыг ойлгоход арай дөхөм нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Тиймээс багш нар зорилтот хэл, соёлын салшгүй уялдааг тусгасан сургалтын арга, технологийг сургалтанд бүтээлчээр ашиглах мэргэжлийн хариуцлага хүлээхийн зэрэгцээ багшийн хөгжлийн асуудлууд ч хамтдаа шийдэгдэх онцлогтой юм.



3. ДУГНЭЛТ

Гадаад хэл сурахад оюутнаас сэтгэхүйн хурд, хүлээж авах чадварын төлөвшил шаардаж байдгийг судалгааны үр дүн харуулж байна.

Үндэсний сэтгэлгээний хэв шинжийн үүднээс зорилтот хэлийг сурахад үндэсний соёлын үнэлэмжийн жишиг хэмжүүр /эталон/-ийг харгалзах нь сургалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, оюутны сурах идэвхийг сайжруулах давуу талтай болохыг тандалт болон туршилт судалгааны дүнгээс харж байна.

Мэргэжлийн англи хэлний хичээлийг заахад тааралддаг метафорыг хэл соёлын шүтэлцээнд тулгуурлан сургалтын холимог арга, технологийг ашиглах нь оюутны гадаад хэл сурах бодит хэрэгцээг хангахад зохих нөлөө үзүүлэх нь бидний туршилт хичээлээр батлагдлаа.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

I. Монгол хэлээр хэвлэгдсэн бүтээл

Б.Сумъяа. (1998). Нүүдэлчид ба соёл. In Б.Сумъяа, *Монголын нүүдэлчдийн соёл* 101-106х Улаанбаатар хот: Адмон ХХК.

Ж.Баянсан. (2002). *Соёл, хэл, үндэсний сэтгэлгээ*. Улаанбаатар.

Ц.Магсар. (2016). Цаг үе ба метафорчилах сэтгэлгээ.

Ц.Оюунцэцэг, Ж. (2016). Гадаад хэл соёл, даяарчлал. *Гадаад хэл заах арга зүйн асуудал*, 47-49х

Ц.Оюунчимэг. (2012). *Их, Дээд сургуулийн заах арга зүйн ухаан*. Улаанбаатар: Соёмбо Принтинг.

II. Гадаад хэлээр хэвлэгдсэн бүтээл

Byram, M. (1988). *Cultural Studies in Foreign Language Education*. The University of Michigan: Multilingual Matters.

Carroll, J. B. (1958). *Language, thought and Reality: Selected Writings of Benjamin Lee Worf*. Massachusetts: MIT Press.

Kramsch, C. (1995). Context and Culture in Language Teaching. *Applied Linguistics, Volume 16, Issue 2*, 264-267.

Lackoff, G. (2002). *Metaphors we live by*. The University of Chicago Press.

В.А.Маслова. (2007). Введение в когнитивную лингвистику. Москва.

